

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

/2016 оны 01 сарын 20-ны өдрийн байдлаар /


Хүнсний болон өргөн хэрэглээний гол нэрийн барааны дундаж үнийг 2008 оны 5-р сараас эхлэн 7 хоногийн давтамжтайгаар судалж байна.

МАХНЫ ҮНЭ


2016 оны 01 сарын 20-ны өдрийн байдлаар Баруун сайхан, Зүүн сайхан, Хан-уул, худалдааны төвд байрлалтай мах, ногооны захын ханшаар хонины 1 кг мах дунджаар 4333 төгрөгөөр, ямааны мах 3500, адууны мах 4000 төгрөгөөр тус тус худалдаалагдаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хонины мах 38.4 хувь, ямааны махны 47.6 хувь, адууны мах 25.0 хувиар тус тус буурсан байна. Харин өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад хонь, ямааны махны үнэ 330-350 төгрөгөөр, адууны махны үнэ 100 төгрөгөөр тус тус өсчээ.

Зураг1.Махны үнэ 2016 оны 1сар


Хонины махны үнэ, 1 кг, төгрөгөөр



Адууны махны үнэ, 1 кг, төгрөгөөр




Ямааны махны үнэ, 1 кг, төгрөгөөр



ГУРИЛ, БУДАА, СҮҮ, ЭЛСЭН ЧИХРИЙН ҮНЭ

2016 оны 01-р сарын 20-ны өдрийн байдлаар малын шингэн сүү худалдаанд зарагдахгүй байна. Харин цагаан будааны үнэ дунджаар 2300 төгрөг, элсэн чихрийн үнэ дунджаар 1933 төгрөг, алтан тариа 1-р гурил 1233 төгрөгөөр худалдаалагдаж байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад элсэн чихрийн үнэ 3.5 хувиар буурч, алтан тариан гурил 19.4 хувиар, цагаан будааны үнэ 15.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Харин өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.


Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, гурилын үнэ, 2016 оны 1 сар, төгрөгөөр



АВТОБЕНЗИН, ДИЗЕЛИЙН ТҮЛШНИЙ ҮНЭ

2016 оны 01-р сарын 20-ны өдрийн байдлаар Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж байгаа Шатахуун түгээх газруудын мэдээгээр бензин А-80 дунджаар 1650 төгрөг, бензин АИ-92 дунджаар 1890 төгрөг, дизелийн түлш дунджаар 1910 төгрөгийн үнэтэй худалдаалагдаж байгаа нь өмнөх долоо хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.

Зураг 3. Автобензин, дизелийн түлшний үнэ, 2016 он 01 сар, төгрөгөөр



ЯМААНЫ НООЛУУРЫН ҮНЭ

2016 оны 01-р сарын 20-ны өдрийн байдлаар Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж буй түүхий эдийн захад ямааны ноолуур зарагдахгүй байна.

Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс.